В. Үндэсний илтгэл боловсруулах арга зүй ба зөвлөлдөх ажиллагаа

4. Үндэсний илтгэлд хүний эрхийг хамгаалах, түүнийг хөхиүлэн дэмжих үйл ажиллагааны бодлого, хамрах хүрээ, тэдгээрийн хэрэгжилт болон хэрэгжүүлэх механизмын талаар тусгав. Түүнчлэн хүний эрхийг хамгаалахад учирч буй хүндрэл, бэрхшээл, тэдгээрийг даван туулах арга замын талаар өөрийн саналыг багтаасан болно.

5. Үндэсний илтгэлийг Хүний эрхийн Зөвлөлийн 2007 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 5/1 дүгээр Тогтоолоор батлагдсан удирдамж болон A/HRC/6/L.24 тоот Баримт бичигт тусгагдсан "Ээлжит Нэгдсэн Хэлэлцүүлэг"-ийн дагуу Мэдээлэл бэлтгэх тухай Ерөнхий Удирдамж зэргийг тус тус баримтлан боловсруулав.

6. Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан үндэсний илтгэл бэлтгэх Ажлын хэсэг үндэсний илтгэл бэлтгэх хугацаанд нийт 3 удаа хуралдсан бөгөөд Монгол Улсын Хүний эрхийн үндэсний Комисс (цаашид "ХЭҮК" гэх) болон хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага (цаашид "ТББ" гэх)-ууд болон мэргэжлийн хүмүүстэй санал солилцох уулзалтыг янз бүрийн түвшинд хэд хэдэн удаа хийсэн болно. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын алба (цаашид "ХЭДКА" гэх)-тай хамтран Үндэсний илтгэл бэлтгэх тухай сургалт-семинарыг 2010 оны 1 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан бөгөөд дээрх сургалтад төрийн болон ТББ-ын нийт 70 гаруй төлөөлөгч оролцов. Түүнчлэн, 2010 оны 2 дугаар сард НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газар, олон нийтийн байгууллага оролцсон 3 талт зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж илтгэл боловсруулах асуудлаар чөлөөтэй санал бодлоо солилцов. Мөн Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн www.humanrights.mn веб хуудсанд үндэсний илтгэл бэлтгэхтэй холбоотой мэдээллүүдийг 2010 оны 05 дугаар сарын 12-ны өдөр байрлуулах зэргээр энэ хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээ олон нийтэд тухай бүрт ил тод байлгахад анхаарал түлхүү хандуулав.